

НИЙТЛЭЛИЙН НЭР:

**ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГО БА
ТОГТОЛЦООНЫ СУДАЛГАА ГЭЖ ЮУ
ВЭ? ЯАГААД ЧУХАЛ ВЭ?**

НИЙТЛЭЛ БИЧСЭН:

**Ц.БАДАМХАТАН, ТӨРИЙН
УДИРДЛАГЫН МАГИСТР, ХТХАА-НЫ
МЭРГЭЖИЛТЭН**

Ерөнхий ойлголт

Эрүүл мэндийн бодлого ба тогтолцооны судалгаа гэдэг нь (Health policy and systems research HPSR) шинээр үүсэн бий болж буй нэг салбар бөгөөд бүх нийтийн эрүүл мэндийн зорилгод хүрэхийн тулд нийгэм өөрөө хэрхэн бүтцээ зохион байгуулж, сайжруулж байгаа болон оролцогч талууд бодлогын үр дүнг дээшлүүлэхийн тулд хэрхэн хамтарч харилцан ажиллаж буйг судалдаг. ДЭМБ-ын тодорхойлсоноор эрүүл мэндийн тогтолцоо гэдэг нь эрүүл мэндийг дэмжих, хадгалах, сэргээх зорилготой бүх байгууллага, хүмүүс, тэдний үйлдэлийг хэлнэ гэжээ. Хамрах хүрээний хувьд ЭМБТС (Эрүүл мэндийн бодлого ба тогтолцооны судалгаа) нь шинжлэх ухаан хоорондын нэгдэл бөгөөд эдийн засаг, нийгмийн ухаан, хүн судлал, улс төр судлал, нийгмийн эрүүл мэнд болон эпидемиологи зэрэг салбарыг хамрах бөгөөд өргөн хүрээгээрээ эрүүл мэндийн тогтолцоо нь эрүүл мэндийн бодлогод хэрхэн хариу урвал үзүүлж, дасан зохицож буй болон эрүүл мэндийн бодлого нь өөрөө эрүүл мэндийн тогтолцоог хэрхэн хэлбэржүүлж буйг тодорхойлон судалдаг.

Эрүүл мэндийн бодлогын болон тогтолцооны судалгаа нь бодлогын төсөлд асуудал дэвшүүлэн оруулахаас эхлээд хэрэгжсэн бодлогод үнэлгээ хийн түүнээс суралцах хүртэлх бодлого боловсруулах үе шатын аль ч хэсэгт ашиглагдаж болно. Тиймээс ЭМБТС нь ямар нэгэн тогтсон судалгааны аргачлал, загварт хязгаарлагдахгүй бөгөөд харин дэвшүүлж буй асуудлаасаа хамаардаг. Гэхдээ ЭМБТС нь эрүүл мэндийн байгууллагын болон бодлогын макро түвшний ойлголтыг хөндөхөөс бус эмнэлзүйн, урьдчилан сэргийлэлтийн эсвэл шинжлэх ухааны ерөнхий сэдвийг (эсийн эсвэл молекулын бүтэц, тодорхой нэгэн өвчлөл гэх мэт) хөндөхгүй болно. Санхүүжилт, засаглал гэх мэт өргөн хүрээний ойлголтоос эхлээд төрийн болон хувийн эрүүл мэндийн байгууллагуудын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болон түүний хэрэгжилтийг тойрсон асуудлуудыг хамарна. Ингэснээр тухайн орон нутгийн, үндэсний болон дэлхийн түвшин дэх үүрэг хариуцлага, ашиг сонирхол, үнэ цэнэ зэргийг илтгэх маш чухал бодлогын баримт бичиг, явцын шинжилгээний хэрэгсэл болдог.

Жишээ нь: анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд нийгмийн ажилтнуудыг оролцуулан өргөтгөх ёстой юу? Гүйцэтгэлд суурилсан цалингийн тогтолцоо нь эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын үйлчлүүлэгчдээ хандах байдлыг сайжруулж, эмчилгээ үйлчилгээний чанарыг дээшлүүлэх үү? Гэх мэт маргаан дагуулсан асуудлуудад нотолгоо баримт бүрдүүлвэл шийдвэр гаргах явц хөнгөрөх боломжтой. Хэрвээ хувийн эрүүл мэндийн байгууллагуудаар анхан шатны зарим тусламж үйлчилгээг гүйцэтгүүлвэл тэдэнтэй ямар байдлаар хамран ажиллах вэ? Гэрээ байгуулвал ямар гэрээ байх вэ, хэрхэн тэдэнтэй тохиролцох вэ? Эрүүл мэндийн даатгалын тогтолцоонд шинэчлэл хийхээр болвол хэн үүнийг эсэргүүцэх магадлалтай вэ, тэр эцэргүүцлийг хэрхэн даван гарах вэ? Зэрэг асуултад ЭМБТС нь хариу өгөх, боломжгүй байлаа гэхэд шийдвэр гаргалтад хэрэглэгдэх зөвлөмж зөвлөгөөг бүрдүүлж чадна.

Дээрх салбар хоорондын уялдааг судлахдаа ЭМБТС нь ямар бодлого амжилттай хэрэгжиж байна гэдгийг дангаар нь судлахаасаа илүү бодлого хэнд, ямар орчин нөхцөлд хэрэгжиж байна гэдгийг тодруулан гаргаж ирдэгээрээ онцлог юм.

Тэмдэглэл 1

Эрүүл Мэндийн Тогтолцооны Судалгааны Өгөөж

Сүүлийн үед хийгдсэн нэгэн судалгаагаар¹ шинэ технологид хөрөнгө оруулах болон ашиглалтыг нэмэгдүүлэх судалгаанд хөрөнгө оруулах хоёрын өгөөжийг харьцуулан судалжээ. Тав хүртэлх насны хүүхдийн нас баралтыг бага орлоготой 42 оронд судлаад дараах дүгнэлтийг гаргасан байна. Үүнд: технологийг сайжруулахад хүүхдийн нас баралт

Эрүүл мэндийн бодлого ба тогтолцооны судалгаа гэж юу вэ? Яагаад чухал вэ?

21,5%-р буурах боломжтой байхад, байгаа нөөцийн ашиглалтыг дээшлүүлэхэд 62,5%-р нас баралт буурсан байна. Тусламж үйлчилгээний болон ашиглалтын судалгааны өгөөж ийм өндөр байхад судалгааг санхүүжүүлэгч хоёр томоохон байгууллагын нийт хөрөнгийн 97% нь шинэ технологийг хөгжүүлэхэд зарцуулагдаж байна хэмээн ижил төрлийн өөр нэгэн судалгаанд дурьдагджээ.

Эрүүл мэндийн бодлогыг тогтолцооны судалгаатай хоршуулах нь

Яагаад эрүүл мэндийн бодлого болон тогтолцооны судалгаа хоёрыг нэгтгэсэн бэ? Онолын хувьд эрүүл мэндийн бодлогын судалгаа нь оролцогч талууд бодлогын хэрэгжилтэд ямар үүрэгтэйгээр хэрхэн оролцож хоорондоо хамтран ажиллан, бодлогын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлдэгийг судалдаг бол эрүүл мэндийн тогтолцооны судалгаа нь хүртээмж, чанар, үр ашиг, тэгш байдал зэрэг асуудлуудыг дэвшүүлдэг ч ЭМБТС нь дараах байдлаар хоршиж илүү үр дүнд хүрэх боломжтой. Үүнд:

Эрүүл мэндийн бодлого нь тогтолцоог удирдаж буй засгийн болон улс төрийн үйл явцын нөлөөн дор байдаг. Эдгээр үйл явцыг ойлгож мэдэх нь үр дүнтэй бодлого боловсруулахад амин чухлаас гадна уг бодлогод мэдээлэл, нотолгоо болж өгдөг. Эрүүл мэндийн бодлого болон тогтолцоо нь тусдаа ойлголт биш бөгөөд ЭМБТС нь энэ холбоо хамаарлыг тод харуулж өгдөг.

- Эрүүл мэндийн тогтолцооны үйл явц болон динамикийг ажигласнаар бодлого болон шийдвэр гаргалтад шууд нөлөөлөх боломжтой.
- Эрүүл мэндийн тогтолцооны судлаачид болон бодлого боловсруулагчид, бусад судалгаа хэрэглэгчдийг холбож өгсөнөөр нотолгоонд суурилсан бодлого болон бодлогод тулгуурласан судалгаа хийх боломжийг бүрдүүлдэг.
- Хэрэгжиж дууссан бодлогын үр дүнд судалгаа хийж түүнээс суралцахад тогтолцооны өргөн хүрээгээр авч хандах нь чухал байдаг бөгөөд энэхүү боломжийг олгоно.
- Тус тусдаа буй эдгээр хоолойг чөлөөлсөнөөр эрүүл мэндийн бодлого боловсруулагч болон судлаачдыг чадавхжуулж, аль алинд нь мэргэшсэн, хөрвөх чадвар бүхий хүний нөөцийг бэлтгэхэд нэн тэргүүний ач холбогдолтой.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас тодорхойлсон эрүүл мэндийн тогтолцооны зургаан тулгуур багана:

- *Тусламж үйлчилгээ* – тусламж үйлчилгээг хэрхэн зохион байгуулж, удирдаж, хүртээмж, чанар, аюулгүй байдлыг өвчлөлийн төрлөөр, эрүүл мэндийн байгууллагаар болон цаг хугацааны туршид хэрхэн зохион байгуулж байгааг судална.
- *Мэдээлэл нотолгоо* – мэдээллийн бүрдүүлэлт болон түүнийг стратегийн зорилгоор ашиглах, нотолгоо, судалгааг удирдлага, манлайлал, засаглалд хэрэглэх.
- *Эрүүл мэндийн бүтээгдэхүүн болон технологи* – эрүүл мэндийн нэн шаардлагатай бүтээгдэхүүн болон технологийн хүртээмж, тэгш байдал, түүний чанар, аюулгүй байдал, үр ашиг, бүрэн ашиглалт зэргийг хангана.
- *Эрүүл мэндийн ажиллах хүч* – хөдөлмөрийн хөдөлгөөнт зах зээлийг удирдах, эрүүл мэндийн ажиллах хүчний орох болон гарах урсгалыг хянах, ажиллаж буй хэсгийн тэгш хуваарилалт болон гүйцэтгэлийг хангана.
- *Эрүүл мэндийн санхүүжилт* – иргэдийг эрүүл мэндийн эрсдлээс шалтгаалсан санхүүгийн хүндрэлээс хамгаалах, шаардлагатай тусламж үйлчилгээг хүн бүрт

Эрүүл мэндийн бодлого ба тогтолцооны судалгаа гэж юу вэ? Яагаад чухал вэ?

хүргэх санхүүгийн боломжийг бүрдүүлэхийн тулд нөөц сангийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангана.

- *Манлайлал ба засаглал* – үр дүнтэй бодлого зохицуулалт, тогтолцооны бүтцийн асуудалд хандуулж буй анхаарал, эгэх хариуцлагыг нэмэгдүүлэх, олон нийтийн сонирхлыг хамгаалах бодлогын явцыг хангана.

Эрүүл мэндийн бодлого ба тогтолцооны судалгаанд тулгарч буй сорилтууд

ЭМБТС нь үүсэл хөгжлийн эхний үеээсээ эхлээд хүндрэл, сорилтуудтай тулгарч байсныг 1975 оны Эрүүл мэндийн Судалгааны Зөвлөх Комиссын тэмдэглэлээс харж болно. Улс төрийн болон нийгмийн бүтэц, эрүүл мэндийн тогтолцооны нийлмэл байдал зэргээс шалтгаалан нэг улс оронд хийгдсэн судалгааг нөгөө улсад нэвтрүүлэх боломжгүй байдаг нь хүндрэлтэй хэмээн тэмдэглэжээ. Мөн түүнчлэн судалгааны дэвшүүлсэн асуудлаас хамааран ерөнхий дүгнэлт гаргах боломж тун хомс байдаг. Жишээ нь: тодорхой нөхцөлд нийгмийн ажилтан нь хүүхдийг хөхөөр хооллолтыг дэмжих ажилд чухал үүрэг гүйцэтгэж болох хэдий ч өөр нэгэн нөхцөлд, сургалтын төрлөөс, хяналт чанга сулаас, хөхөөр хооллолтыг дэмждэг эсвэл дэмждэггүй нийгмийн соёлоос шалтгаалан бүгд өөр өөр үр дүн гарах боломжтой. Тиймээс дээрх нийлмэл байдал болон ерөнхийлөх боломжгүй үр дүнгээс шалтгаалан ЭМБТС нь тэр бүр олны анхаарлыг татаж нэр хүндийг олж авч чаддаггүй байх магадлалтай. Өөр нэгэн сул тал нь эрүүл мэндийн судалгааг ихэвчлэн эмч мэргэжилтнүүд болон ерөнхий шинжлэх ухаанаар дагнасан судлаачид хийж гүйцэтгэдэг бөгөөд эрүүл мэндийн бодлого болон тогтолцоо, улс төр, эдийн засгийн нөхцөл байдлын талаар ойлголт багатай байдаг оршино. Түүнчлэн ЭМБТС нь санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлэх, төсвийн төлөвлөлтөд багтсан хязгаарлагдмал нөөцөд захирагдан хийж гүйцэтгэдэг нь томоохон хүндрэл үүсгэдэг. Хэдий тийм ч эрүүл мэндийн бодлого ба тогтолцооны судалгаа нь зөвхөн дата болон үзүүлэлтүүдийг үүсгэн бий болгохоос гадна талуудын хооронд ардчилсан мэтгэлцээн өрнүүлэх баримт болон шүүмжүүдийг бүрдүүлдэгээрээ давуу талтай.

Эрүүл мэндийн Судалгааны Олон улсын Форумын онцолсоноор эрүүл мэндийн судалгааны зардлын зөвхөн 10% нь л хөгжиж буй орнуудын иргэдийн эрүүл мэндийн асуудалд зарцуулагдаж байхад эрүүл мэндийн бодлого болон тогтолцооны нөхцөл байдал нь эдгээр улсуудад хамаагүй хурцадмал байдалд байна хэмээжээ. Сүүлийн үеийн нэгэн судалгаагаар² эрүүл мэндийн бодлого болон тогтолцооны судалгааны чиглэлээр хэвлэгдсэн нийтлэлүүдийн зөвхөн 5% нь хөгжиж буй орнуудын асуудлыг хөндсөн байгааг дурьджээ.

Эдгээр асуудлуудыг шийдвэрлэхийн тулд нэн тэргүүнд ЭМБТС-нд ашиглагддаг нэр томъёог нэгдсэн ойлголтод оруулах, ЭМБТС-гаар мэргэшсэн байгууллага, судлаачдын чадамжийг нэмэгдүүлэх, санхүүжилтийн эх үүсвэрийг татах, шийдвэр гаргалтад судалгааны ашиглалтыг нэмэгдүүлэх, ЭМБТС-ны хөгжлийг дэмжих, чиглүүлэх, хянах зэрэг ажлуудыг авч хэрэгжүүлэх нь чухал шаардлагад тооцогдож байна.

Ашигласан материалын жагсаалт

1. Leroy J.L., Habicht J-P., Pelto G and Bertozzi S.M. (2007) "Current prioritize in health research funding and lack of impact on the number of child deaths per year". *American Journal of Public Health* 97(2):219-223.
2. Alliance for Health Policy and Systems Research (2004) *Strengthening Health Systems: The role and promise of policy and systems research* Global Forum for Health Research, Geneva.
3. World Health Organization (WHO). (2018) What is health policy and systems research (HPSR).
4. Gilson, L. (2012). Health policy and systems research. *A Methodology Reader*. Geneva: World Health Organization & Alliance for Health Policy Systems Research.